



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 4/18

Мандалговь

Хөдөлмөрийн дотоод журамд  
нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Орон нутгийн өмчийн газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын тавдугаар бүлэгт 5.8, 5.9, долоодугаар бүлэгт 7.2.10, 7.2.11, 7.2.12, 7.2.13, 7.3.10, 7.3.11, 7.3.12, 7.3.13, 7.3.14, 7.3.15, 7.3.16, 7.3.17, 7.3.18, 7.5.11, 7.5.12, 7.5.13 дахь хэсгийг тус тус нэмсүгэй.

2. Дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах зохицуулалтыг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (М.Золбоо)-д даалгасугай.

4. Хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажилдаа хариуцлага, санаачлагатай хандан, төрийн үйлчилгээг чанартай зохион байгуулж, төрийн албан хаагчийг ёс зүйг мөрдөн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

5. Нэмэлтээр журамлагдсан зохицуулалтыг газрын даргын тушаал гарсан едрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



• 482412060

Орон нутгийн өмчийн газрын даргын  
2024 оны 08... -р сарын 28.. өдрийн  
11.. дугаар тушаалын хавсралт

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРМЫН  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

**Тав. Албан хаагчдыг албан тушаалд томилох,  
чөлөөлөх, түр чөлөөлөх, халах**

5.8.Албан хаагч, ажилтнуудыг шинээр ажил, албан тушаалд томилоход төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, ёс зүйн хэм хэмжээ болон хүний эрх, хүний эрх хамгаалагчийн эрхтэй холбоотой мэдээлэл бүхий хуудсыг танилцуулж, гарын үсэг зуруулж хөвшил.

5.9.Шинээр томилогдсон албан хаагч, ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрт хүний эрхийн зөрчил болон хүний эрх хамгаалагчийн эрх, хориглох зүйлийн талаарх агуулгыг тусгах.

**Долоо. Хөдөлмөрийн сахилга, хариуцлага**

**7.2 Байгууллагын үүрэг**

7.2.10.Албан хаагч, ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрт хүний эрх болон хүний эрх хамгаалагчийн эрхийн талаарх агуулгыг тусган баталж, төрөлжүүлсэн хэлбэрээр сургалт зохион байгуулах.

7.2.11.Хууль бусаар албан хаагчид болон хүний эрх хамгаалагчийн эрхийг аливаа хэлбэрээр хязгаарлахгүй, зөрчихгүй байх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

7.2.12.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжих, тэдний эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах, гаргасан хүсэлт, шаардлагыг биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзахгүй байх.

7.2.13.Ажлын байран дахь хүний эрхийн зөрчил болон хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж, зөрчил үүсгэж байгаа шалтгаан нөхцөл, нөлөөлөгч хүчин зүйлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх.

**7.3.Албан хаагчийн эрх**

7.3.11.Зан харилцаа, уг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.

7.3.12.Төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх.

7.3.13.Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй, ялгаварлан гадуурхахгүй байх.

7.3.14.Бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй уг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус уг, хэллэг хэрэглэхгүй байх.

7.3.15.Хүний эрх, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны талаарх сургалтад хамрагдах, холбогдох мэдээллээр хангуулах.

7.3.16.Хуулийн хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулах, оролцох, үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангуулах.

7.3.17.Хүний эрхийн зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, хамгаалалтаар хангуулах.

7.3.18. Хүний эрх хамгаалагчийн талаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг шаардах.

**7.5.Албан хаагчийн хориглох зүйл**

7.5.11.Төрийн алба хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг уг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах.

7.5.12.Хүний эмзэг болон хувийн мэдээллээр бусдыг гутаах.

7.5.13.Соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах.

----oOo----